



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/35

Амардалай

Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 31 дүгээр зүйлийн 31.3, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.5 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Хаданхошуу 1- 103 тоот)-д байршилтай иргэн Сугир овогтой Отгонцэцэг (ЗЕ41021516)-ийн Авто машины засвар, үйлчилгээний зориулалттай 1200 м.кв (0.1 га) газрын зориулалтыг худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар өөрчилж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулж сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн А/13 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшиж буй газраа гэрээнд заасан болзлын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ

4323010009